



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН 5.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ТАХ АШИГЛАЛТГҮЙ
БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”

АУДИТЫН КОД: ДАА-2025/06-7-ШТА-НА



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Сувдмаа

Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Э.Одгэрэл

Утас: 70378845 Цахим хаяг: odgerele@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн

Утас: 70378845 Цахим хаяг: khulansuren@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

Аудитын ерөнхий мэдээлэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, МҮЕА-ын 2024 оны А/108, 2025 оны А/15 дугаар тушаалыг үндэслэн Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, “ДХББЗГ” ОНӨААТҮГ болон гүйцэтгэгч ААН-ийн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах шалгагдагч байгууллагаас авсан бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Сувдмаа, аудитор Г.Батмягмар, Э.Одгэрэл, Н.Хулансүрэн нар гүйцэтгэсэн.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар нийт 61,916.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 410.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 61,506.0 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Монгол Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгасан зорилго зорилтын хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон боловч Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу зураг төсөв, боловсруулаагүй, магадлалаар баталгаажуулаагүй ТАХ-ний саналыг хүргүүлсэн байна.
2. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох, тендерийн баримт бичгийг боловсруулахдаа хууль журамд нийцүүлсэн байна.
3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгож байгаа ч захиалагч, зохиогчийн хяналтын зардлыг бүрэн олгохгүй, төвлөрүүлээгүй байна.
4. Гэрээний хугацаанд батлагдсан зураг төсөв, техникийн шаардлагын дагуу 25 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 31.6 хувь хугацаандаа дуусаагүйгээс гэрээг сунгасан байна.
5. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнээс 55,625.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 5,451.5 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтад оруулаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Б.Азжаргал танаа:

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах санал хүргүүлэхдээ зураг, төсөв боловсруулж магадлалаар баталгаажуулсан байх
2. Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа хяналтын зардлын 150.8 сая төгрөг, нормчлолын сангийн 70.6 сая төгрөг, зөвлөх үйлчилгээний 120.0 сая төгрөг, зураг, төсвийн 88.0 сая төгрөгийг холбогдох байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулан холбогдох дансдад төвлөрүүлэх
3. ТАХ-ний зураг төсөв, техникийн тодорхойлолт бусад холбогдох баримт материалыг ХААГ-т цаг алдалгүй хүргүүлж байх
4. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, хөрөнгийг холбогдох сургуулиудад хүлээлгэн өгч, данс бүртгэлд тусгуулах

Аймгийн “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр танаа:

1. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллага нь чанарын баталгаат хугацаанд ашиглалтын явцын хяналтыг сайжруулах

Аймгийн ОНӨГ-ын дарга Д.Бат-Эрдэнэ танаа:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх он болон тайлант онд бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-г Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.5.2-т заасныг хэрэгжүүлж, өмчийг бүртгэлжүүлэх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

- Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймагт хэрэгжиж дууссан 25 ТАХ-ний бүртгэлд авах жагсаалтыг хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлээгүй асуудлыг ТӨБЗГ-т уламжлах

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹⁹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2025.04.18

¹⁹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ